



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

"Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасны дагуу Цагаан сарын баярын өдрүүдэд 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 08.00 цагаас 03 дугаар сарын 06-ны өдрийн 08.00 цаг хүртэлх хугацаанд хариуцлагатай жижүүр томилох тухай зорилгоор ТУШААХ нь:

1.Цагаан сарын баярын өдөр Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас ажиллах хариуцлагатай жижүүрийн ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Баярын өдрүүдэд үндсэн үүрэгт ажил болон Агаарын хөлгийн осол, зөрчлийн талаар дүрмийн дагуу тайлан мэдээ, мэдээллээр хангахыг хариуцлагатай жижүүрт үүрэг болгосугай.

3.Баярын өдрүүдэд ажилласан хариуцлагатай жижүүрт хяналт тавьж ажиллах, энэ хугацаанд гарсан мэдээ, мэдээллийг нэгтгэж танилцуулахыг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны Ахлах шинжлэн шалгагч Х.Наранхүүд даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН

My documents /тушаал/ а4

1725 0010002



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн
батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1, 122.2 дахь хэсэг, Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн 4.4.6 дахь заалтын тус тус үндэслэн ТУШААХ нь: нь

1.Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/298 дугаар тушаалаар Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны бүтэц, орон тоо, дүрмийг шинэчлэн батлагдсантай холбогдуулж тус албаны Хөдөлмөрийн дотоод журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны Хөдөлмөрийн дотоод журмыг нийт ажилтнуудад танилцуулж, сурталчлахыг Захиргаа судалгааны тасагт үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалыг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны даргын 2019 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/12 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН

My documents /тушаал/ а4

1725 01 0004



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Гарын бэлэг олгох тухай

Хөдөлмөрийн дотоод журмын 8.11 дэх заалтын тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Мартын 8-ны баярыг тохиолдуулан Агаарын хөлгийн, осол зөрчлийг шинжлэн шалгах албаны хавсралтад дурдсан нэр бүхий эмэгтэй ажилтнуудад тус бүр 100.000 (зуун мянга) төгрөгийн гарын бэлэг олгосугай.
- 2.Гарын бэлэгт зарцуулагдах зардлын холбогдох журмын дагуу тооцон олгохыг Нягтлан бодогч (Х.Баярмаа)-д зөвшөөрсүгэй.
- 3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавиж ажиллахыг (Захиргаа судалгааны тасаг)-т даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Бэлэг тэмдэг батлах тухай

Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8, 43 дугаар зүйлийн 43.4.7., АХОЗШША-ны дүрмийн 1.9. дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны бэлгэ тэмдэг", "Бэлгэ тэмдэгийг ашиглах гарын авлага"-ыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Бичиг хэрэг, туслах ажилтан (О.Тэгшжаргал)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

Урамшуулал олгох тухай

“Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм”-ийн 4.4.9, 4.4.10 дахь заалтууд “Хөдөлмөрийн дотоод журам-ын 3.9.5 заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан тус албаны 16 хүртэлх насны хүүхэдтэй хавсралтад дурьдагдсан ажиллагсдын хүүхэд бүрт урамшуулал олгосугай.

2. Албаны ажиллагсдын хүүхэд бүрт урамшуулал олгохыг Санхүү нягтлан бодогч (Х.Баярмаа)-д зөвшөөрсүгэй.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.-д заасны дагуу Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдрүүдэд 2025 оны 07 дугаар сарын 10-ний өдрийн 06.00 цагаас эхлэн 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 06.00 цаг хүртэлх 8 хоногийн хугацаанд хариуцлагатай жижүүр томилох зорилгоор ТУШААХ нь:

1. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдрүүдэд Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас ажиллах хариуцлагатай жижүүрийн ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баярын өдрүүдэд үндсэн үүрэгт ажил болон агаарын хөлгийн осол, зөрчлийн талаар дүрмийн дагуу мэдээ мэдээллээр хангахыг хариуцлагатай жижүүрт үүрэг болгосугай.

3. Баярын өдрүүдэд ажилласан хариуцлагатай жижүүрт хяналт тавьж ажиллах, энэ хугацаанд гарсан мэдээ, мэдээллийг нэгтгэж танилцуулахыг агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжлэн шалгагч Х.Наранхүүд даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Шинжлэн шалгах багийг томилох тухай

Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, АХОЗШША-ны дүрмийн 2.2, 2.3-ын заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.МИАТ ХХК-ийн EI-MNG бүртгэлийн дугаартай B737-MAX8 маягийн агаарын хөлөг 2025.08.04-ны өдөр Токио-Улаанбаатар чиглэлд OM502 дугаарт нислэг үйлдэж байх үед агаарын хөлөг битүүмж алдагдаж Осака хотын Кансай (KIX) олон улсын нисэх буудалд буусан шалтгааныг тогтоох шинжлэн шалгах багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Шинжлэн шалгах багийн ахлагч:

Х.Наранхүү

(Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжлэн шалгагч)

Гишүүд:

Ч.Буянбадрах

(Нислэгийн шинжлэн шалгагч)

Ч.Шинэбаяр

(Техникийн шинжлэн шалгагч)

2.Шинжлэн шалгах ажиллагааны дүрэм, зааврын дагуу хийж гүйцэтгэхийг багийн ахлагч (Х.Наранхүү)-д үүрэг болгосугай:

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН

My documents /тушаал/ а4

1725 01 0014



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Ажлын хэсэг томилох тухай

“Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 9 дүгээр бүлэгийн 43.1 дэх заалт, Зам, Тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/298 тоот тушаалаар батлагдсан “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба”-ны дүрмийн 4.1., 4.4.10 дахь заалт, Хөдөлмөрийн дотоод журамын 5.15, 5.16, 5.17, 5.18, 5.19, 5.20, 5.21, ба 7.5 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн аюулгүй байдлын аудит хөтөлбөр-байнгын хяналтын аргачлалын хүрээнд Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-аас 2026 онд хийгдэх аудит шалгалтанд хамрагдах бэлтгэл ажлыг хангах Ажлын хэсгийг 2025 оны 09 дүгээр сарын 01-нээс 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл дараах бүрэлдэхүүнтэйгээр томилон ажилуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Ганхуяг
(Нислэгийн хөдөлгөөний шинжлэн шалгагч)

Гишүүд:

Ч.Шинэбаяр
(Техникийн шинжлэн шалгагч)

Х.Баярмаа
(Санхүү нягтлан бодогч)

П.Гэрэлчимэг
(Техникийн шинжлэн шалгагч)

Нарийн бичгийн дарга:

С.Баттулга
(Бүртгэл судалгааны мэргэжилтэн)

2.Аудит шалгалын бэлтгэл ажлыг хангах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төлөвлөгөө боловсруулж 2025 оны 09 дүгээр сарын 10-ны дотор багтаан танилцуулахыг ажлын хэсэг (Г.Ганхуяг)-т үүрэг болгосугай.

3.Ажлын хэсгийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулах зорилгоор ажлын хэсгийн ажилтнуудад ажлын гүйцэтгэл үр дүнг харгалзан ахлах шинжлэн шалгагч хэсгийн

(Ханхуяг)

• 1725 01 0016

ахлагч нарын тодорхойлсноор сар бүр үндсэн цалингийн 40 хүртэл хувийн нэмэгдэл хөлс олгохыг Санхүү, нягтлан бодогч (Х.Баярмаа)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах шинжлэн шалгагч (Х.Наранхүү)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Бичлэг тайлах програм хангамж хүлээн
авах комисс байгуулах тухай

Зам, тээврийн сайдын “Бүтэц орон тоо дүрэм батлах тухай” 2024 оны А/298 дугаар тушаал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 зүйлийн 36.1.1 дэх заалт, Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны 2025 оны батлагдсан төсөв, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025.09.24-ний өдрийн А-1/1753 тоот албан бичгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Люмина-3Д “Нислэгийн хөдөлгөөнт систем” 2025-Mongolia-001 Rev1 дугаартай гэрээний дагуу бараа хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Х.Наранхүү
(Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжлэн шалгагч)

Гишүүд: П.Гэрэлчимэг
(Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны техникийн шинжлэн шалгагч)

С.Баттулга
(Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны бүртгэл, судалгааны мэргэжилтэн)

2.Бичлэг тайлах програм хангамжийг техникийн тодорхойлолтын дагуу шалгаж, комиссын акт, холбогдох материалыг бүрдүүлэн хүлээн авахыг комиссын дарга (Х.Наранхүү)-д холбогдох хууль, журмын дагуу үндсэн хөрөнгөд бүртгэж, бүртгэлээр хяналт тавихыг санхүү, нягтлан бодогч (Х.Баярмаа)-д тус тус үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН

My documents/тушаал а4/

1725 010018



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Шинжлэн шалгах багийг томилох тухай

"Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, АХОЗШША-ны дүрмийн 2.2, 2.3-ын заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэн Жамсранжавын Наранбаатарын эзэмшилд буй JU-8060 бүртгэлийн дугаартай "Sport Star" маягийн хэт хөнгөн агаарын хөлөг 2025.10.02-ны өдөр УБ-Баянхонгор чиглэлд хувийн зорилгоор нислэг үйлдэж байх үед тус агаарын хөлөг Баянхонгор нисэх буудлын хөөрөх, буух зурвасан дээр газардах үед осолд орсон шалтгааныг тогтоох зорилгоор шинжлэн шалгах багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Шинжлэн шалгах багийн ахлагч:

Х.Наранхүү

(Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжлэн шалгагч)

Гишүүд:

Ч.Буянбадрах

(Нислэгийн шинжлэн шалгагч)

Ч.Шинэбаяр

(Техникийн шинжлэн шалгагч)

2.Шинжлэн шалгах ажиллагааны хууль, дүрэм, зааврын дагуу шинжлэн шалгах ажиллагааг хийж гүйцэтгэхийг багийн ахлагч (Х.Наранхүү)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН

My documents /тушаал/ а4

1725 0010021



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн гэрээний загвар батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн 4.4.10, Хөдөлмөрийн дотоод журмын 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ажилтнуудтай байгуулах хөдөлмөрийн гэрээний үлгэрчилсэн загварыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахлах шинжлэн шалгагч (Х.Наранхүү)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН

My documents/тушаал/a4

1725 01044



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын
баримт бичгийг батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 100 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт, хөтлөх аргачлал", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам", Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн 4.4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/298 дугаар тушаалаар Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны бүтэц, орон тоо, дүрмийг шинэчлэн батлагдаж Санхүүгийн нэгжтэй болсонтой холбогдуулж тус албаны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хавсралтаар баталсугай.

2.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллахыг, Санхүү, нягтлан бодогч (Х.Баярмаа)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН

My documents/тушаал/a4

1725 01447



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

Норм батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн 4.4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжлэн шалгагч нарын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн жагсаалт, эдэлгээний нормыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалыг мөрдөж ажиллахыг Ахлах шинжлэн шалгагч (Х.Наранхүү)-д, хяналт тавьж ажиллахыг Санхүү, нягтлан бодогч (Х.Баярмаа)-д тус тус даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН

My documents/тушаал/а4

1735 010050



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дугаартай тогтоолоор баталсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Бүртгэл, хяналтын журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. "Бүртгэл хяналтын журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг албаны нийт ажилтнуудад даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Гадаад улсад томилолтоор ажиллуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сангийн сайдын 2011 оны "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" 188 дугаар тушаал, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/59 тоот тушаалаар баталсан заалтыг үндэслэн тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын иргэний нисэхийн байгууллага/ICAO/ болон Иргэний нисэхийн аюулгүй байдлын аудит хөтөлбөр, байнгын хяналтын аргачлал (USOAP CMA)-ын шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулагдаж байгаа сургалт, семинарт оролцуулахаар тус албаны нислэгийн хөдөлгөөний шинжлэн шалгагч Г.Ганхуяг техникийн шинжлэн шалгагч Ч.Шинэбаяр нарыг 2025 оны 11 дүгээр сарын 8-ны өдрөөс 15-ны хооронд Тайланд улсын Бангкок хотод томилон ажиллуулсугай.

2. Албан хаагчийн томилолтоор ажиллахад баримтлах удирдамжийг нэгдүгээр, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Томилолтоор ажилласан тухай тайланг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор танилцуулахыг тус албаны шинжээч Г.Ганхуяг, Ч.Шинэбаяр нарт үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН

My documents/тушаал/a4/

1725 010040



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Хэвлэмэл хуудсан дээр үйлдэх
Баримт бичгийн нэр төрөл, индексийг
батлах тухай

“Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам-ын” 2.2.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны хэвлэмэл хуудсан дээр үйлдэх баримт бичгийн нэр төрөл, индексийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа судалгааны тасаг (П.Гэрэлчимэг)-т даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Шинжлэн шалгагч нарын мэргэшлийн зэрэг
болон мэргэжлийн ур чадварыг хадгалах
журмыг батлах тухай

Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын баримт бичиг /DOC9756, P1/-ийн 2.4.2, 2.4.3 дахь заалт, Зам, Тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 298 тоот тушаалын нэгдүгээр хавсралт “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм”-ийн 4.4.26 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны “Шинжлэн шалгагч нарын мэргэшлийн зэрэг болон мэргэжлийн ур чадварыг хадгалах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахлах шинжлэн шалгагч Х.Наранхүү, Санхүү, нягтлан бодогч (Х.Баярмаа) нарт тус тус даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН



ШИНЖЛЭН ШАЛГАГЧ НАРЫН МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ БОЛОН МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫГ ХАДГАЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журам нь Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ийн баримт бичиг /DOC9756, P1/-ийн 2.4.2, 2.4.2 дах заалт болон Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн шинэчилсэн найруулга, Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 298 тоот тушаалын нэгдүгээр хавсралт “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм”-ийн 4.4.26. заалтыг тус тус үндэслэн боловсруулагдсан.

1.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгагч нар нь мэргэжлийн ур чадварыг хадгалах дараах сургалт дадлагат хамрагдсан байна. Үүнд:

- 1.2.1. анхан шатны сургалт
- 1.2.2. ажлын байран дээрх сургалт
- 1.2.3. Шинжлэн шалгах ажиллагааны шинжлэн шалгагчийн үндсэн сургалт
- 1.2.4. Шинжлэн шалгах ажиллагааны тусгай сургалт
- 1.2.5. Хурал семинар
- 1.2.6. Шинжлэн шалгах ажиллагаанд ажиглагчаар оролцох
- 1.2.7. Суурь мэргэжил /нисгэгч, инженер, нислэгийн хөдөлгөөний удирдагч/-ийн сургалт дадлага, мэргэшлийн зэрэг хадгалах;

1.3. Энэ журмын 1.2.7-д заагдсан сургалт, дадлагаас бусад сургалтыг албаны “Aircraft Accident Investigation Policy and Procedures Manual” /Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах бодлого, үйл ажиллагааны заавар /-ийн дагуу зохион байгуулж хэрэгжүүлнэ.

1.4. Шинжлэн шалгагч нарын суурь мэргэжил /нисгэгч, инженер, нислэгийн хөдөлгөөний удирдагч/-ийн мэргэшлийн зэрэг болон сургалт дадлагыг энэ журмаар зохицуулна.

ХОЁР. УР ЧАДВАР БОЛОН МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙГ ХАДГАЛАХ

2.1. Энэ журмын 1.2.7-д заагдсан нислэгийн удирдлагын шинжлэн шалгагчийн мэргэшлийн зэргийг Иргэний нисэхийн үндэсний төвийн захирлын “Нислэгийн хөдөлгөөний удирдагчид мэргэшлийн зэрэг олгох журам” болон ур чадвар хадгалах сургалтыг “Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын баталсан “Нислэгийн

удирдагчийн мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл эзэмшигчдийн ур чадвар хадгалах журам"-ын дагуу хэрэгжүүлж болно.

2.2. Техникийн шинжлэн шалгагчийг шаардлагатай гэж үзвэл мэргэшлийн зэрэг болон суурь мэргэжлийн ур чадвар /инженер/-ийг хадгалах зорилгоор түүний өмнө нь эзэмшсэн агаарын хөлгөөс бусад агаарын хөлгийн шилжин сургалтанд суралцуулж болно.

2.3. Техникийн шинжлэн шалгагчийг агаарын хөлгийн үйлдвэрлэгчдээс зохион байгуулж байгаа холбогдох хурал семинарт оролцуулах

2.4. Хэрэв шинжлэн шалгагч нь нисгэгчийн мэргэжлийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй тухайн төрлийн агаарын хөлгөөр нислэг үйлдэж байгаа бол түүний нислэгийн ур чадварыг алдагдуулахгүй байх шаардлагатай.

2.5. нислэгийн шинжлэн шалгагч нь нислэгийн ур чадвараа хадгалах нислэг үйлдэхдээ иргэний нисэхийн холбогдох дүрэм, тухайн компанийн нислэгийн үйл ажиллагааг зохицуулж байгаа дүрэм, зааврын дагуу гүйцэтгэнэ.

2.6. Нислэгийн шинжлэн шалгагч нь тухайн төрлийн агаарын хөлгийг эзэмшигч, ашиглагч байгууллагын эрх бүхий этгээдтэй хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр нислэгийг үйлдэнэ.

2.7. Нислэгийн шинжлэн шалгагчийн суурь мэргэжлийн ур чадварыг хадгалах зорилгоор хийгдэж байгаа нислэгийг үндсэн ажлын цагийн нөхцөл байдалд уялдуулан ахлах шинжээч зохион байгуулж ажиллана.

2.8. Нислэгийн шинжлэн шалгагч нь өөрийн эзэмшсэн агаарын хөлгөөр сард 20 хүртэл цагийн нислэгийг үйлдэж болно.

2.9. Нислэгийн шинжлэн шалгагчийн нислэг үйлдсэн цагийг төрийн болон хувийн агаарын тээврийн компаниудын нислэгийн удирдлагуудын нэгэн адил ажилласан цагт тооцож бүртгэнэ.

2.10. ахлах шинжлэн шалгагч нь нислэг үйлдэгч шинжлэн шалгагчийг шинжлэн шалгах ажиллагаанд ашиг сонирхолын зөрчилд орохгүй байх нөхцөл боломжоор хангаж, хяналт тавьж ажиллана.

2.11. Нислэгийн шинжлэн шалгагч нь нислэгт явах өдрийг урьдчилан мэдэгдэх бөгөөд захиргааны менежер нислэгийн цагийн хэтрэлтэнд хяналт тавина.

2.11. Нислэг үйлдэж байгаа шинжлэн шалгагч нь Иргэний нисэхийн дүрмийн шаардлагын дагуу жил бүрийн эрүүл мэндийн үзлэг болон нислэгийн шалгалт, дадлагжуурт хамрагдаж байна.

ГУРАВ. МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ БОЛОН СУРГАЛТ ДАДЛАГЫН ЗАРДАЛ ОЛГОХ

3.1 Энэ дүрмийн 2.1-д заагдсан мэргэшлийн зэргийн нэмэгдэлийг Иргэний нисэхийн үндэсний төвийн захирлын “Нислэгийн хөдөлгөөний удирдагчид мэргэшлийн зэрэг олгох журам” –ын дагуу олгоно.

Үүнд: Мэргэшлийн I-р зэрэг -20%

Мэргэшлийн II-р зэрэг -15%

Мэргэшлийн III-р зэрэг -10%

3.1. Энэ дүрмийн 2.1, 2.2, 2.3. заагдсан сургалт дадлагын зардлыг нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны зардлын төсөвт тусгуулан хэрэгжүүлэнэ.

3.2. Нислэгийн шинжлэн шалгагчийн үйлдвэрлэлийн нислэгт оролцсон цалин болон энэ журмын 2.11-д заагдсан үзлэг, дадлагын зардлыг нислэг үйлдэж байгаа байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр тухайн байгууллагын зардалд тусгаж хэрэгжүүлнэ.



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Шинжлэн шалгагч нарт мэргэшлийн зэргийн
нэмэгдэл олгох тухай

“Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм”-ийн 4.4.26 дахь заалт, Иргэний нисэхийн дүрэм 65-ын дагуу Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл эзэмшигч, “Шинжлэн шалгагч нарын мэргэшлийн зэрэг болон мэргэжлийн ур чадварыг хадгалах журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн үндэсний төвийн захирлын “Нислэгийн хөдөлгөөний удирдагчид мэргэшлийн зэрэг олгох журмын дагуу шалгалтанд хамрагдаж мэргэшлийн зэрэг горилсон дараах шинжлэн шалгагч нарт, Иргэний нисэхийн үндэсний төвийн 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 02-3/1525 тоот шийдвэрт дурдагдсан нэр бүхий албан тушаалтанд Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны “Шинжлэн шалгагч нарын мэргэшлийн зэрэг болон мэргэжлийн ур чадварыг хадгалах журмын хүрээнд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгосугай.

2.Мэргэшлийн зэрэг горилсон шинжлэн шалгагч нарт “Шинжлэн шалгагч нарын мэргэшлийн зэрэг болон мэргэжлийн ур чадварыг хадгалах журмын дагуу 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг Санхүү, нягтлан бодогч (Х.Баярмаа)-д зөвшөөрсүгэй.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Гадаадад томилолтоор ажиллуулах тухай

Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 298 тоот тушаал, Сангийн сайдын 2011 оны "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" 188 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий зориулалтын агаарын хөлөг болон хэт хөнгөн агаарын хөлгүүдийн аюулгүй байдлыг хангах зориулалтыг судалж, хэрэгжүүлэх зорилгоор АНУ-ын Миссури мужийн Branson, Spring Field хотуудын жижиг оврын агаарын хөлгийн сургалтын байгууллагууд Premier Flight Center, IFR FLIGHT CLUB, Tri-Lakes RC Flying Club-т ажиллуулахаар ахлах шинжлэн шалгагч Х.Наранхүүг 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 22-ны хооронд томилон ажиллуулсугай.

2. Албан хаагчийн томилолтоор ажиллахад баримтлах удирдамжийг нэгдүгээр, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Томилолтоор ажилласан тайланг 2025 оны 12 дугаар сарын 30-ны дотор танилцуулахыг ахлах шинжлэн шалгагч (Х.Наранхүү)-д даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН



АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Ажлын хэсгийг шинэчилэн томилох тухай

“Иргэний нисэхийн тухай” Монгол улсын хуулийн 9 дүгээр бүлгийн 43.1 дэх заалт, Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/298 тоот тушаалаар батлагдсан “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба”-ны дүрмийн 4.1., 4.4.10 дахь заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 5.15., 5.16., 5.17., 5.18., 5.19., 5.20., 5.21., ба 7.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн аюулгүй байдлын аудит хөтөлбөр-байнгын хяналтын аргачлалын хүрээнд Олон улсын иргэний нисэхийн байгууллага(ICAO)-аас 2026 онд хийгдэх аудит шалгалтанд хамрагдах бэлтгэл ажлыг хангах Ажлын хэсгийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл дараах бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Ганхуяг
(Нислэгийн хөдөлгөөний шинжлэн шалгагч)

Гишүүд:

Ч.Шинэбаяр
(Техникийн шинжлэн шалгагч)

Х.Баярмаа
(Санхүү, нягтлан бодогч)

П.Гэрэлчимэг
(Техникийн шинжлэн шалгагч)

Ч.Буянбадрах
(Нислэгийн шинжлэн шалгагч)

О.Тэгшжаргал
(Бичиг хэрэг, туслах ажилтан)

Нарийн бичгийн дарга:

С.Баттулга
(Бүртгэл, судалгааны мэргэжилтэн)

1725 019679

2.Аудит шалгалтын бэлтгэл ажлыг хангах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу ажиллаж гүйцэтгэлийг сар бүрийн сүүлийн долоо хоногт багтаан танилцуулж байхыг ажлын хэсгийн ахлагч (Г.Ганхуяг)-т үүрэг болгосугай.

3.Ажлын хэсгийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулах зорилгоор ажлын хэсгийн ажилтнуудад ажлын гүйцэтгэл үр дүнг харгалзан ахлах шинжлэн шалгагч, хэсгийн ахлагч нарын тодорхойлсноор сар бүр үндсэн цалингийн 40 хүртэл хувийн нэмэгдэл хөлс олгохыг Санхүү, нягтлан бодогч (Х.Баярмаа)-д зөвшөөрсүгэй.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах шинжлэн шалгагч (Х.Наранхүү)-д үүрэг болгосугай.

5.Энэ тушаал гарсантай холбогдуулан 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/08 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН